

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ



## Нийслэлийн Дотоод аудитын алба

ЭРҮҮЛ АЖЛЫН  
БАЙР

2016  
ОН

Улаанбаатар хот

## АЖЛЫН ТАЙЛАН

Нийслэлийн Дотоод аудитын албаны даргын 2016 оны А/21 дүгээр тушаалаар эрүүл ажлын байр бий болгох, үүний дагуу төлөвлөгөө гарган ажиллахыг Биеийн тамир, спорт хамтлагт даалгасан. Биеийн тамир спорт хамтлаг нь спортын төлөвлөгөөтэй уялдуулан дараах ажлуудыг хийсэн. Үүнд:

1. Тус албаны 22 албан хаагч 2016 оны 05 дугаар сарын 11-ны өдрөөс 31-ний хооронд Гранд мэд эмнэлэгт эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан ба нийт 22 төрлийн шинжилгээг өгч мэргэжлийн эмчийн зөвлөгөө, зааврыг авсан. Үүнд:

- Биеийн ерөнхий үзлэг
- Цусны дэлгэрэнгүй шинжилгээ
- Шээсний ерөнхий шинжилгээ
- Элэгний үйл ажиллагаа
- Өөх тосны солилцоо
- Элэгний В, С вирус
- Үе мөчний шинжилгээ
- Бөөрний үйл ажиллагаа
- Эрдэсүүд
- Нойр булчирхайн шинжилгээ /сахар, амилаз
- Зүрхий цахилгаан бичлэг
- Хэвлийн хэт авианы шинжилгээ /эхo/
- ЭХО
- Ясны сийрэгжилт
- Цээж нурууны рентген
- Дотрын эмчийн үзлэг
- Нүдний эмчийн үзлэг /уг дурандах/
- Чих, хамар, хоолойн эмчийн үзлэг
- Мэдрэлийн эмчийн үзлэг
- Арьс харшлын эмчийн үзлэг
- Эмэгтэйчүүдийн эмчийн үзлэг
- Мэс заслын эмчийн үзлэг

2. Албан хаагчдыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор ажлын байранд хийх дараах арван төрлийн дасгалыг өдөрт 2 удаа буюу 11 цаг, 16 цагуудад тогтмол хийж байна. Үүнд:

- Амьсгалын дасгал
- Хүзүүний булчин суллах дасгал
- Мөрний үений дасгал
- Гараа дээш ээлжлэн өргөх дасгал
- Цээж эргүүлэх дасгал
- Бүсэлхийн үений дасгал
- Доод үе мөчний дасгал
- Сунгалтын дасгал
- Бөхийх дасгал
- Анхаарал төвлөрүүлэн тайвшруулах дасгал



3. Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас 2016 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 08:30-17:30 цагийн хооронд зохион байгуулсан нийслэл, дүүрэг, хороодын нутгийн захиргааны байгууллагын биеийн тамир, спортын хамтлагийн ахлагч нарын дунд “Эрүүл ажлын байр таниас эхэлнэ” сэдэвт сургалт, семинар явагдаж тус сургалтад биеийн тамир, спорт хамтлагийн ахлагч Б.Уранбилэг хамрагдсан. Тус сургалтын хүрээнд ажлын байрны шинэчлэгдсэн дасгалын талаар болон эрүүл хооллолтын талаарх мэдээллийг албан хаагчдад өгсөн.
4. Мөн ажиллагсдыг хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх зорилгоор долоо хоног бүрийн мягмар гарагийн 19:30 цагаас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын “Сүлд” спорт хорооны зааланд сагсан бөмбөг, гар бөмбөгөөр хичээллэж байна.





5. Албан хаагчдад анхан шатны тусламж үзүүлэх зорилгоор эмнэлгийн анхан шатны тусламж хэрэгсэл болох даралтын аппарат, эм, боох материалыг ажлын байранд тусгай хайрцагтай гарын доор байршуулсан.
6. Ажлын байранд эрүүл гэрийн хоолоор хооллох боломжийг хангах зорилгоор богино долгионы зуух, хөргөгч зэргийг байршуулж ажиллах тав тухтай нөхцөлийг бий болгосон.

ТАЙЛАН БИЧСЭН:

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХАМТЛАГИЙН  
АХЛАГЧ

Б.УРАНБИЛЭГ

ХЯНАСАН:

НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ  
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ЖАВЗАН